

**“ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН
ШАЛГАРУУЛАХ” АЖЛЫН ДААЛГАВАР**

2025 оны 5 дугаар сарын 22- ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

1.	Үндэслэл	Сүхбаатар дүүргийн 9,10,11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжихээр төлөвлөгдсөн дэд бүтэц, авто зам, нийтийн зориулалттай байгууламжуудын газрын чөлөөлөлтийн ажил хийгдэж, хууль ёсны дагуу иргэн, хуулийн этгээдүүдийн эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газрыг чөлөөлсөн байна. Гэвч эдгээр чөлөөлсөн газруудыг зохих хамгаалалтгүй орхисноор буцаан дур мэдэн эзэмших, зориулалтын бусаар ашиглах, хог хаягдал хуримтлуулах, түр барилга, байгууламж барих зэрэг зөрчил гарч, нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөх эрсдэл өндөр байна. Иймд дээрх газруудад тодорхой хугацаанд харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлж, байнгын хяналт тавих, ямар нэгэн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, газар чөлөөлөлтийн ажлын үр дүнг хамгаалах, нийтийн эзэмшлийн зориулалтаар ашиглах нөхцөлийг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Энэхүү хамгаалалтын үйл ажиллагаа нь нийслэлийн газрын бодлогын хүрээнд хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг үр дүнтэй, саадгүй хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.
2.	Зорилго	Улаанбаатар хотын нийгэм эдийн засаг, хөгжлийн асуудлыг оновчтой шийдэж, хүн амын эрүүл, аюулгүй, ажиллаж амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн нийслэлийн газруудыг хамгаалалтанд байлгах зорилготой.
3.	Хамрах хүрээ	Рашаант 18-32а, Рашаант 20-5, Рашаант 19-34а, Рашаант 20-3а, Рашаант 20-3б, Барилгачид 3-60 Чингэлтэй 18-440, Алтайн 7-203, Алтайн 3-86 Алтайн-3-81б, Алтайн-3-83б, Алтайн 7-15, Нуур-7-36, Алтайн-10-5, Алтайн-10-39, Алтайн 23-50, Чингэлтэй 19-452, Рашаант 18-19, Рашаант 17-13, Рашаант 17-13А, Рашаант 17-14, Рашаант 17-53, Рашаант 17-54а, Рашаант 17-54б, Рашаант 18-1-2, Рашаант 18-1-1Рашаант 17-8БРашаант17-39 Рашаант 17-50Рашаант 15-54Рашаант 17-35Алтайн 27-157а Алтайн 10-8, Алтайн 23-27, Алтайн 9-261, Алтайн 22-31, Рашаант 18-10а, Рашаант 18-10б, Барилгачид 3-84, Барилгачид 4-95, Алтай 9-65

4.	Ажил гүйцэтгэлийн хугацаа	2025 оны 06 сараас 2025 оны 12 сар дуустал
5.	Гүйцэтгэгч мэргэжлийн байгууллагын тусгай шаардлага	Ажил гүйцэтгэгч нь дараах болно. - Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас олгодог - Харуул хамгаалалтын ажлын тусгай зөвшөөрөл. - Радио давтамж ашиглах эрхийн зөвшөөрөл. - Харуул хамгаалалтын 4 доошгүй ажилтантай /Харуул хамгаалалтын ажилтны сургалтад хамрагдсан байх, 25-50 насны, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан зохих боловсрол, ажлын туршлагатай байх/ - Ажилтнууд нь иргэний үнэмлэх, гэрээт харуул хамгаалалтын албан хаагчаар бэлтгэгдсэн мэргэжлийн үнэмлэх ирүүлнэ. - Санал болгож буй Харуул хамгаалалтын ажилтнууд нь мэргэжлийн гэрчилгээ, сертификат байх. Соёлч, боловсон харилцаатай, эрүүл мэндийн шаардлага хангасан байх. Харуул хамгаалалтын ажлын 1 жилээс доошгүй туршлагатай талаар тодорхойлолт ирүүлнэ. -Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримтыг шаардана. - Тээврийн хэрэгслийн мэдээллийг доорх хүснэгтийн дагуу зургаар баталгаажуулж ирүүлнэ. /Авто тээврийн хэрэгслийн эзэмшигчийн лавлагааг цахим системээр дамжуулан шалгана - Хамтран болон гүйцэтгэж байсан ажлын гэрээ, гэрээ дүгнэсэн акт бусад холбогдох бичгүүд;
6.	Гүйцэтгэх ажил, үе шат	- Хүлээлгэн өгсөн газар, хашаа, самбарын бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалах, хүлээлгэж өгөх
7.	Хүлээн авах ажил үйлчилгээ	- Газар, хашаа, самбарын бүрэн бүтэн байдлыг хангах
8.	Санхүүжилтийн эх үүсвэр	Орон нутгийн төсөв - 16,800,000 төгрөг
9.	Захиалагч байгууллага:	Нийслэлийн Орон сууцны бодлогын газар
10.	Хаяг:	Нийслэлийн Орон сууцны бодлогын газар Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 Наадамчдын зам 1200, Арцадын гудамж, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилга, “Б” корпус 9 дүгээр давхар, 904 тоот

Боловсруулсан:

Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн Ч. Чулуунгэрэл